



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 124

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 112,968,695.00 (нэг зуун арван хоёр сая есөн зуун жаран найман мянга зургаан зуун ерэн таван) төгрөгийн балансын үнэ, 59,878,808.91 (тавин есөн сая найман зуун далан найман мянга найман зуун найман төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Багануур-А33А” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Талын зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Т.Бямбадорж, “Багануур-А33А” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Алтангадас нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

А.АРИУНБОЛД

0000251

Төрийн эмчийн Бодлого зохицуулалтын газрын 2019 оны 04 дугаар сарын 22-ны өдрийн 447 дугаар тогтоолын хавсралт

“Талын зам” ТӨХК-иас “Багануур-АЗЗА” ТӨХК-ийн балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт

Д/д	Эд хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/А шиглалтанд орсон огноо	Хэм жих нэгж	Тоо ширхэг	Нийт гүйлт мото /цаг	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	РҮ-165С маркийн, УБ 48-55 улсын дугаартай, автогрейдер, Хөдөлгүүрийн дугаар -87223795	2011/2011	ш	1	10850	112,968,695.00	59,878,808.91	53,089,886.09
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН								
						112,968,695.00	59,878,808.91	53,089,886.09
						112,968,695.00 (нэг зуун арван хоёр сая есөн зуун жаран найман мянга зургаан зуун ерэн таван)	59,878,808.91 (тавин есөн сая найман зуун далан найман мянга найман зуун найман төгрөг ерэн нэгэн мөнгө)	53,089,886.09 (тавин гурван сая наян есөн мянга найман зуун наян зургаан төгрөг есөн мөнгө)